



44

МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 492

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дугаар тогтоол, Засгийн газрын 2011 оны 108 тоот тогтоолоор батлагдсан “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1.6, 3.6 дахь заалт, “Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2011-2015), Эрүүл мэндийн лабораторийг хөгжүүлэх үндэсний стратеги (2010-2015)-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, лабораторийн тусламж, үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор ТУШААХ нь:

1. “Халдварт өвчний үүсгэгч илрүүлэх, баталгаажуулах, мэдээлэл солилцох лабораторийн сүлжээний бүтэц, ажиллах журам”-ыг нэгдүгээр, “Халдварт өвчний хам шинж, сэжигтэй тохиолдлын үед цуглуулах сорьц, хийх шинжилгээний нэр, төрлийн жагсаалт”-ыг хоёрдугаар, “Халдварт өвчний үүсгэгч илрүүлэх, баталгаажуулах шинжилгээ хийх лабораториудад байх багаж, тоног төхөөрөмжийн жагсаалт”-ыг гуравдугаар, “Халдварт өвчний үүсгэгч илрүүлэх, баталгаажуулах шинжилгээ хийх лабораториудад байх урвалж бодис, лабораторийн хэрэгслийн жагсаалт”-ыг дөрөвдүгээр, “Лабораторийн мэдээлэл дамжуулах урсгал”-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх журам, жагсаалт батлагдсантай холбоотойгоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд мөрдүүлж, хэвшүүлэхийг төв эмнэлэг, төрөлжсөн, тусгай мэргэжлийн төв, амаржих газар, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, тосгон, сум, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, ор бүхий хувийн эмнэлгүүд болон бусад нян судлал, вирус судлал, ийлдэс судлалын лабораторийн тасаг нэгжтэй эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Шинжилгээний дүнгийн мэдээлэл, мэдээллийн сан бүрдүүлэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал)-т даалгасугай.

САЙД



Н. УДВАЛ

002578



45

Эрүүл мэндийн сайдын 2013 оны  
12 сарын 30-ны өдрийн 492 тоот  
тушаалын нэгдүгээр хавсралт

## **ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ҮҮСГЭГЧ ИЛРҮҮЛЭХ, БАТАЛГААЖУУЛАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЛАБОРАТОРИЙН СҮЛЖЭЭНИЙ БҮТЭЦ, АЖИЛЛАХ ЖУРАМ**


### **Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1. Энэ журмын зорилго нь лабораторийн үйлчилгээний чанар, аюулгүй ажиллагаа, стандарт хангалтыг анхан, дунд, үндэсний түвшинд бэхжүүлж, халдварт өвчний үүсгэгчийг үнэн зөв, шуурхай илрүүлэх, лавлах, баталгаажуулах нөхцлийг сайжруулахад оршино.
- 1.2. Халдварт өвчний оношилгоо, дэгдэлтийн шинжилгээ хийж байгаа улсын болон хувийн лабораториуд энэ сүлжээнд үе шаттайгаар хамрагдана.
- 1.3. Халдварт өвчний үүсгэгч илрүүлэх, баталгаажуулах лабораториуд өөр хоорондоо болон олон улсын лавлагаа лабораториуд, эрүүл мэндийн системийн холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох үүрэгтэй ба энэхүү Эрүүл мэндийн лабораторийн сүлжээ (цаашид сүлжээ гэх) нь ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн Нэгдсэн лабораторийн алба (НЛА)-ыг түшиглэн ажиллана.

### **Хоёр. Сүлжээний зохицуулга, бүтэц**

- 2.1. ЭМЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас сүлжээний удирдан зохицуулах хороо, ажлын хэсгийг томилж, ЭМЯ-ны Лабораторийн болон Няан судлалын мэргэжлийн салбар зөвлөлүүд сүлжээний үйл ажиллагаанд зөвлөх үүрэг гүйцэтгэнэ.
- 2.2. Халдварт өвчний үүсгэгч илрүүлэх, баталгаажуулах, мэдээлэл солилцох лабораторийн сүлжээний толгойлогч байгууллага нь ХӨСҮТ-ийн НЛА байна.
- 2.3. ХӨСҮТ-ийн НЛА-нд лабораторийн сүлжээний ерөнхий зохицуулагч орон тоогоор ажиллаж лабораториудын хоорондын уялдаа холбоог зохицуулна.
- 2.4. Сүлжээний ерөнхий зохицуулагч нь ХӨСҮТ-ийн НЛА-ны чанарын менежер, хангамж, аюулгүй ажиллагаа хариуцсан менежерүүдтэй хамтран ажлын алба бүрдүүлж ажиллана.
- 2.5. Сүлжээнд хамрагдаж байгаа бүх түвшингийн лабораторийн төлөөллийг оролцуулан зөвлөлдөх уулзалтыг жилд 1 удаа зохион байгуулна.





- 2.6. Лабораториуд нь тухайн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт, үйлчлэх хүрээний хүн амын тоонд нийцүүлэн хүний нөөцийн орон тоогоо бүрдүүлж ажиллана.
- 2.7. Лабораторийн сүлжээ нь анхан, дунд, үндэсний түвшний гэсэн гурван шатлалын лабораториудаас бүрдэнэ. Үүнд: Тосгон, сум, ерхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, дүүргийн болон хүүхдийн түргэн тусламжийн төвүүдийн лабораториуд анхан шатны; Улсын төв эмнэлэг, төрөлжсөн, тусгай мэргэжлийн төвүүд, аймаг, нийслэлийн ЭМГ, БОЭТ, Дүүргүүдийн ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн лабораториуд, амаржих газрууд, ор бүхий хувийн эмнэлгүүдийн лаборатори, Хувийн хэвшлийн лабораториуд дунд шатны; ХӨСҮТ-ийн Нян судлал, Вирус судлал, Бэлгийн замаар дамжих халдварын лаборатори, Хепатит-Энтеровирус, Дархлаа судлалын лаборатори, Сүрьеэгийн лаборатори, Паразитологийн лаборатори, ЗӨСҮТ-ийн лабораториуд үндэсний түвшинд тус тус ажиллана.


**Гурав. Сүлжээний удирдан зохицуулах хорооны үүрэг**

- 3.1. Сүлжээ лабораториудын чадавхийг нэмэгдүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах
- 3.2. Лабораторийн стратеги, төлөвлөгөөг сүлжээний лабораториуд хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих
- 3.3. Сүлжээний ажлын хэсэг, лабораториудын үйл ажиллагаанд чиглэл өгч, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах
- 3.4. Сүлжээний үйл ажиллагаанд шаардлагатай техникийн болон санхүүгийн дэмжлэгийг Засгийн газар болон хандивлагч байгууллагуудад тавьж, шийдвэрлүүлэх
- 3.5. Салбар хоорондын хамтын ажиллагааг хангах
- 3.6. Олон улсын лавлагаа лаборатори, хүрээлэнгүүдтэй хамтын ажиллагаа тогтооход туслах

**Дөрөв. Сүлжээний ерөнхий зохицуулагч, ажлын албаны үүрэг**

- 4.1. Сүлжээ лабораториудын өдөр тутмын харилцаа, хамтын ажиллагааг зохицуулах
- 4.2. Лабораториудын үйл ажиллагаа, ажил үүргийн хэрэгжилтийг хянах
- 4.3. Мэдээлэл цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэл бэлтгэх, мэдээлэх
- 4.4. Лабораторийн үйл ажиллагааны стандарт, аюулгүй ажиллагаа, чанар хангалтын үйл ажиллагаанд зааварчилгаа өгөх
- 4.5. Чанарын хяналт, үнэлгээний ажлыг зохион байгуулах, мэдээлэх
- 4.5. ХӨСҮТ-ийн вэб сайтад лабораторийн мэдээлэл боловсруулж тавих





**Тав. Сүлжээ лабораториудын гүйцэтгэх үүрэг**


**5.1 Үндэсний түвшний лабораторийн үүрэг**

- 5.1.1 Лабораторийн стандарт, шинжилгээний аргачлал, гарын авлага, бодлогын баримт бичиг боловсруулна.
- 5.1.2 Сүлжээний лабораториудын мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлж, тасралтгүй сургалтаар хангана.
- 5.1.3 Лавлах, баталгаажуулах шинжилгээ хийнэ.
- 5.1.4 Шаардлагатай сорьцыг олон улсын лавлагаа лабораторит илгээж баталгаажуулах ажлыг зохион байгуулна.
- 5.1.5 Лабораторит шинэ технологи нэвтрүүлнэ.
- 5.1.6 Олон улсын стандартыг нутагшуулж, стандартыг тогтмол сайжруулна.
- 5.1.7 Чанарын гадаад хяналт, үнэлгээ хийж мэргэжил арга зүйгээр хангана.
- 5.1.8 Халдварт өвчний үүсгэгч илрүүлэх чанарын гадаад хяналтын дүнг улсын хэмжээнд нэгтгэж, ЭМЯ болон холбогдох байгууллагуудад тайлагнана.
- 5.1.8 Бичил биетний омгийн санг ХӨСҮТ, ЗӨСҮТ-д байгуулна.
- 5.1.9 Бичил биет (Бактери, вирус)-ний эмэнд тэсвэржилтийн хяналт, тандалт судалгаа хийнэ.
- 5.1.10 Сүлжээний лабораториудын мэдээг цуглуулах, дүн шинжилгээ хийж эргэн мэдээлэх, ЭМЯ, ДЭМБ болон бусад хамтран ажиллагч байгууллагуудад зохих журмын дагуу мэдээлнэ.
- 5.1.11 Сүлжээний лабораториудад, лабораторийн тандалтын мэдээ, сургалтын материал, шинжилгээний шинэлэг арга зэргээр эргэн мэдээлэл бэлдэж хүргүүлнэ.
- 5.1.12 Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.
- 5.1.13 Халдварт өвчний хамшинжээр шинжилгээний алгоритм /бүдүүвч-ийг халдварт өвчний хамшинж тус бүрээр гаргаж, шаардлагатай үед шинэчилэн 1 ба 2 дугаар шатлалын лабораториудад хүргүүлнэ.

**5.2 Дунд шатны лабораторийн үүрэг**

- 5.2.1 Шинжилгээг стандарт аргачлалын дагуу хийх
- 5.2.2 Шаардлагатай тоног төхөөрөмж, лабораторийн хэрэгсэл бүхий лабораторийн орчныг бүрдүүлж, чанар аюулгүй ажиллагааг ханган ажиллана.
- 5.2.3. Анхан шатны лабораторийн шинжилгээний дүнг лавлан, баталгаажуулна.
- 5.2.2 Анхан шатны лабораториудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.
- 5.2.3 Гадаад чанарын хяналт үнэлгээнд оролцож жил бүр үнэлгээ авна.
- 5.2.5 Халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үйл явдлын үед орон нутагтаа тандалт хариу арга хэмжээний багт орж ажиллана.
- 5.2.6 Анхан шатны лабораторийн шинжилгээний мэдээг хүлээн авч нэгтгэнэ.
- 5.2.7 Шинжилгээний дүнг мэдээний маягтаар, мэдээллийн урсгалд заасны дагуу мэдээлнэ.






### 5.3 Анхан шатны лабораторийн үүрэг

- 5.3.1 Заагдсан шинжилгээг стандарт аргачлалын дагуу хийнэ.
- 5.3.2 Шаардлагатай тоног төхөөрөмж, лабораторийн хэрэгслийг авч, чанар аюулгүй ажиллагааг ханган ажиллана.
- 5.3.3 Халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үйл явдлын үед сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаж ажиллана.
- 5.3.4 Мэдээг мэдээллийн урсгалын дагуу шинжилгээний мэдээг өгнө.

Халдварт өвчний үүсгэгч илрүүлэх, баталгаажуулах, мэдээлэл солилцох лабораторийн сүлжээний бүтцийн бүдүүвч






Эрүүл мэндийн сайдын 2013 оны  
12 сарын 30-ны өдрийн 492 тоот  
тушаалын хоёрдугаар хавсралт

49

**Халдварт өвчний хам шинж, сэжигтэй тохиолдлын үед сүлжээний лабораторит цуглуулах сорьц, хийх шинжилгээний нэр төрөл**


№	Сэжигтэй болон хам шинж	Авах сорьц	Ялган оношлох өвчнүүд*	Лабораториудын шатлал		
				Анхан	Дунд	Үндэсний
<b>Нэг. Хам шинж</b>						
1	Цочмог халууралт, тууралттай хам шинж	Хамар, хоолойн арчдас, цус, хос ийлдэс, баас	Улаанбурхан	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, өсгөвөрлөх, ПГУ, сиквенс
			Улаанууд	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, өсгөвөрлөх, ПГУ, сиквенс
			Улаан эсэргэнэ	Сорьц цуглуулах	*Наалдац, өсгөвөрлөх, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
			Цитомегало вирүст халдвар	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, ПГУ, өсгөвөрлөх
			Халдварт эритем	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, өсгөвөрлөх, ПГУ
			Хачигт боррелиоз	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, ПГУ
			Хачигт риккетсиоз	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, өсгөвөрлөх, ПГУ
2	Цочмог халууралт, цэврүүт тууралттай хам шинж	Хамар, хоолойн арчдас, цус, хос ийлдэс, цэврүүний шингэн, баас	Салхинцэцэг / Бүслүүр үлд/	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, өсгөвөрлөх, ПГУ, сиквенс
			Гар, хөл, амны өвчин	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, ПГУ, өсгөвөрлөх
			Цитомегаловируст халдвар	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, ПГУ, өсгөвөрлөх
3	Цочмог шарлалттай хам шинж	Ийлдэс, баас	Вирүст гепатит А, В, С, D, E	Хурдавчилсан тест	ФХУ	ФХУ, ПГУ
			Лептоспироз	Сорьц цуглуулах	Наалдац	Наалдац, ДТБХ
			Шар чичрэг	Сорьц цуглуулах	Наалдац	Наалдац, ФХУ
			Вирүсийн болон нянгийн гаралтай	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөрлөх,	Наалдац шинжилгээ,





	Цочмог суулгат хам шинж	Бөөлжис, ходоодны угаадас, ийлдэс, баас, шулуун гэдэсний арчдас	суулгалт халдварууд		АМЧ	өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
			Хоолны халдварт хордлого	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ	Наалдац шинжилгээ, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
			Сальмонеллэз	Сорьц цуглуулах	Наалдац шинжилгээ, өсгөвөрлөх, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
			Булчин задрах тахал	наалдац	Наалдац, өсгөвөр, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
			Шигеллэз	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
			E coli 0157:H7	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
			Холер	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
5	Удаан халуурах хам шинж	Цус, ийлдэс, баас, шулуун гэдэсний арчдас	Балнад, иж балнад	Наалдац	Наалдац, өсгөвөр, АМЧ	Наалдац, өсгөвөр, АМЧ, ПГУ
			Тахлын булчирхайн хэлбэр	Сорьц цуглуулах	Наалдац	Наалдац, өсгөвөрлөх, ПГУ
			Хумхаа	Наалдац	Наалдац	Наалдац, ПГУ
			Лептоспироз	Наалдац	Наалдац	Наалдац, ПГУ
			Денге-ийн халуурал	Наалдац	Наалдац	Наалдац, ПГУ
6	Мэдрэлийн цочмог хамшинж	Хамар, хоолойн арчдас, цус, ийлдэс, тархи нугасны шингэн	Халдварт менингит	Наалдац	Наалдац, Latex, өсгөвөр, АМЧ	Наалдац, Latex, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
			Баруун Нилийн энцефалит	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, ПГУ
			Хачигт энцефалит	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, ПГУ
			Хачигт боррелиоз	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, ПГУ
7	Цусархаг хам шинж/ цус, хос ийлдэс	Цус, хос ийлдэс	Бөөрний хам шинжтэй цусархаг халуурал	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, ПГУ
			Лептоспироз	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, ПГУ






			Крым-Конгын цусархаг халуурал	Сорьц цуглуулах	ФХУ	ФХУ, ПГУ
<b>Хоёр. Сэжигтэй тохиолдол</b>						
1	Цочмог сул саажилт	Хос ийлдэс, тархи нугасны шингэн	Халдварт саа	Сорьц цуглуулах	Сорьц цуглуулах	Өсгөвөрлөх, ПГУ
			Гиллиан-Баррын хамшинж	Сорьц цуглуулах	Сорьц цуглуулах	Өсгөвөрлөх, ПГУ
			Трансмиссив миелит	Сорьц цуглуулах	Сорьц цуглуулах	Өсгөвөрлөх, ПГУ
			Гэмтлийн бус мэдрэлийн үрэвсэл	Сорьц цуглуулах	Сорьц цуглуулах	Өсгөвөрлөх, ПГУ
			Полиобус энтеровирусээр үүссэн сул саажилт	Сорьц цуглуулах	Сорьц цуглуулах	Өсгөвөрлөх, ПГУ
2	Сахуу	Хамар, хоолойн арчдас, цэр, хос ийлдэс	Мононуклёз Улаан эсэргэнэ	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
3	Хөхүүл ханиад	Хамар, хоолойн арчдас, хос ийлдэс	Амьсгалын замын цочмог халдвар, Уушгины үрэвсэл Уушгины сүрьеэ	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
4	Гахай хавдар	Хамар, хоолойн арчдас, цус, ийлдэс	Менингит, менингоэнцефалит, лимфаденит	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
5	Халдварт менингит	Хамар, хоолойн арчдас, цус, ийлдэс, тархи нугасны шингэн	Бактерийн болон вирусийн гаралтай менингитүүд, тархины цус харвалт, тархины гэмтэл	наалдац	Наалдац, Latex, өсгөвөр, АМЧ	Наалдац, Latex, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
6	Галзуу	Хос ийлдэс, тархи нугасны шингэн	Татран, энцефалит	Сорьц цуглуулах	ДТБХ	ДТБХ, ПГУ
7	Нярайн үжил	цус, ийлдэс, тархи	Нярай бусад өвчлөл	Наалдац	Наалдац, өсгөвөр, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ





		нугасны шингэн , арчдас				
8	Татран	Хамар хоолойн арчдас, цус, ийлдэс, тархи нугасны шингэн	Галзуу Энцефалит	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөр, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
9	Нярайн татран	Хамар хоолойн арчдас, цус, ийлдэс, тархи нугасны шингэн	Энцефалит	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөр, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
10	Хоолны хордлого	Бөөлжис, ходоодны угаадас, ийлдэс, баас, шулуун гэдэсний арчдас	Нянгийн болон вирусийн гаралтай суулгалт халдвар, Химийн хордлого Ургамлын хордлого	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ	Наалдац шинжилгээ, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
11	Булчин задрах тахал	Бөөлжис, ходоодны угаадас, ийлдэс, баас, шулуун гэдэсний арчдас	Сальмонеллэз, Шигеллэз, E coli 0157:H7, вирусийн болон нянгийн гаралтай суулгалт халдвар	Сорьц цуглуулах	Наалдац	Наалдац, ПГУ
12	Тарваган тахал	Цус, ийлдэс, баас, шулуун гэдэсний арчдас	Боомын уушгины хэлбэр, лимфаденит, тулерями, пневмони	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөрлөх	Наалдац, өсгөвөрлөх, ПГУ
13	Боомын уушгины хэлбэр	Хамар хоолойн арчдас, цэр, хос ийлдэс	Ёлом, лимфаденит, туляри, пневмони, стафилококкийн гаралтай өвчин	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ





14	АЦХаХ	Хамар хоолойн арчдас, цэр, хос ийлдэс	Шувууны томуугийн хүний өвчлөл, MERS CoV-ийн халдвар, аденовирүсийн халдвар	Сорьц цуглуулах	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ПГУ
15	Томуугийн шинэ вирүсийн халдвар	Хамар хоолойн арчдас, цэр, хос ийлдэс	Шувууны томуугийн А/Н5N1, А/Н7N9, АЦХаХ, MERS CoV-ийн халдвар, аденовирүсийн халдвар	Сорьц цуглуулах	Хурдавчилсан тест, ПГУ	ПГУ, өсгөвөрлөх, сиквенс
16	ДОХ/Бэлгийн замын халдвар	Цус, ийлдэс	ДОХ, Тэмбүү, Заг хүйтэн, Трихоманиоз, Папилома	Хурдавчилсан тест, наалдац	Наалдац, өсгөвөр, АМЧ, ФХУ, RPR	Наалдац, өсгөвөрлөх, АМЧ, ФХУ, иммуно-блотинг, RPR, ТРНА, ПГУ

Тайлбар: \* Тухайн хамшинжийн шалтгаан байж болох хамгийн түгээмэл үүсгэгчдийг илрүүлэх шинжилгээг эхлээд хийнэ. Сөрөг бол ховор тохиолдох үүсгэгчдийг илрүүлэх шинжилгээг хийнэ.



54


Эрүүл мэндийн сайдын 2013 оны  
16 сарын 30-ны өдрийн 19.0 тоот  
тушаалын гуравдугаар хавсралт

**Халдварт өвчний үүсгэгч илрүүлэх, баталгаажуулах шинжилгээ хийх  
лабораториудад байх багаж, тоног төхөөрөмжийн жагсаалт**

№	Багаж	Лабораториудын шатлал		
		Анхан	Дунд	Үндэсний
1	Био-аюулгүйн II зэргийн кабинет		+	+
2	Гэрлийн микроскопи	+	+	+
3	Иммунофлюоресценци микроскопи		+	+
4	Инвертэт микроскопи			+
5	Бактериологийн бүрэн автомат анализатор		+	+
6	Нян будах автомат машин			+
7	Цусны ариун чанар тодорхойлох автомат анализатор		+	+
8	Хатаах шүүгээ		+	+
9	Автоклав		+	+
10	Термостат /энгийн/		+	+
11	CO <sup>2</sup> термостат		+	+
12	CO <sup>2</sup> баллон		+	+
13	Эксикатор		+	
14	Лабораторийн хөргөгч	+	+	+
15	-20 хөлдөөгч		+	+
16	-70 хөлдөөгч		+	+
17	Ус нэрэгч		+	+
18	Усан банн		+	+
19	Центрифуг	+	+	+
20	ELISA уншигч, угаагч, принтер		+	+
21	CD4 тоологч анализатор			+
22	Сэгсрэгч		+	+
23	Автомат соруур	+	+	+
24	ДНХ, РНХ ялгах автомат машин			+
25	ПГУ-ын машин		+	+
26	Гель электрофорезийн аппарат		+	+
27	Лабораторийн жин		+	+
28	Mc форланд фотометр		+	+
29	РН метр		+	+
30	Цилиндр	+	+	+
31	Колбо	+	+	+
32	Бактерийн зүү, гогцоо		+	+



	Бактерийн зүү, гогцоо шатаагч	+	+	+
33	Сорьц зөөвөрлөх сав	+	+	+
34	Компьютер принтер	+	+	+



55



Эрүүл мэндийн сайдын 2013 оны  
12 сарын 30-ны өдрийн 492 тоот  
тушаалын дөрөвдүгээр хавсралт

**Халдварт өвчний үүсгэгч илрүүлэх, баталгаажуулах шинжилгээ хийх  
лабораториудад байх урвалж бодис, лабораторийн хэрэгслийн жагсаалт**


№	Урвалж	Лабораториуд		
		Анхан	Дунд	Үндэсний
1	Наалдацын тавиур шил	+	+	+
2	Граммын будаг	+	+	+
3	Цель Нилсний будаг	+	+	+
4	Нейссерийн будаг	+	+	+
5	Рамоновский Гимзийн будаг	+	+	+
6	Иммерсийн тос	+	+	+
7	Эсийн өсгөвөр			+
8	Эсийн өсгөврийн тэжээлт орчин			+
9	Вирүс тээвэрлэх орчин	+	+	+
10	Бактериологийн автомат анализатор, анализаторийн бактери ялган дүйлтийн болон Антибиотикийн карт		+	+
11	Триптоз буурцгийн агар		+	+
12	Мюллер хинтон агар		+	+
13	Хромо агар		+	+
14	SS агар		+	+
15	Тэжээлт орчны нэмэлтүүд		+	+
16	Стандарт шөл / Bactec, BacAlert, Heamoline/		+	+
17	Бактериологийн сорьц тээвэрлэх орчин	+	+	+
18	API стрип /Strep, NH, 20E, 10S, 20A, Coryne/		+	+
19	Оптохины диск		+	+
20	Вацитрацины диск		+	+
21	Оксидазын диск		+	+
22	X, V, XV фактор тодорхойлох диск		+	+
23	Sh. flexneri антисериум п/в		+	+
24	Sal.O рецептор антисериум поливалент		+	+
25	N.meningitidis antiserum group A, B, C, W135, X, Y		+	+
26	H.influenzae antiserum type b		+	+
27	Антибиотикийн дискүүд		+	+
28	Латекс наалдуулах урвалын цомогууд	+	+	+
29	Vinax NOW туузан оношлуур	+	+	+
30	Гепатит А, В, С илрүүлэх туузан оношлуур	+	+	
31	Тэмбүү илрүүлэх туузан оношлуур	+	+	
32	HIV-ийн туузан оношлуур	+	+	
33	Роза-Бенгалын оношлуур	+	+	
34	H.pylori –ийн туузан оношлуур	+	+	



35	ПГУ-ын цомог		+	+
36	ДНХ ялгах цомог		+	+
37	РНХ ялгах цомог		+	+
38	ELISA цомог оношлуур / HIV, HCV, HBV, HAV, Rubella and Mumps, H. Pylori, Brucella /		+	+
39	ELISA цомог оношлуур / HDV, HEV, Measles, Rubella and mumps, H. Pylori, CMV, Noravirus, Rotavirus, Entervirus, Herpes virus, Brucella /			+
40	Иммуноблотингийн цомог /HIV/			+
41	CD эс тоолох цомог			+
42	Тэмбүү илрүүлэх RPR цомог		+	+
43	Тэмбүү илрүүлэх ТРНА цомог		+	+
44	Райт Хедельсоны оношлуур		+	+
45	Кали теллуритийн сорил	+	+	+
46	Томуу өвчний туузан оношлуур	+	+	
47	Автоклавын индикаторын цаас	+	+	+
48	Мс форланд уусмалууд		+	+
49	РН метрийн цаас	+	+	+
50	Хөргөгч, термостатийн термометр	+	+	+
51	Петрийн аяга		+	+
52	Эс өсгөвөрлөх сав			+
53	Сорьц авах сав/Шээс, цэр, нугасны ус г.м/	+	+	+
54	Хөвөн болон дакрон бамбар	+	+	+
55	Пипеткийн хошуунууд	+	+	+



Эрүүл мэндийн сайдын 2013 оны  
12 сарын 30-ны өдрийн 494 тоот  
тушаалын тавдугаар хавсралт



### Сүлжээний лабораторийн мэдээлэл дамжуулах урсгал

1. Анхан шатны лабораториуд долоо хоногт хийсэн шинжилгээний тоо, үр дүнгээ мэдээний маягтын дагуу нэгтгэж, Даваа гараг бүр II шатлалын лаборатори буюу аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн Эрүүл мэндийн хэлтэст мэдээлнэ.
2. II түвшингийн лабораториуд нь анхан шатны лабораториудын мэдээг нэгтгэн Мягмар гарагт ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн Нэгдсэн лаборатори болон ХӨСҮТ-ийн Тандалтын Үндэсний нэгжид мэдээлнэ.
3. ХӨСҮТ-ийн НЛА нь лабораториудаас ирүүлсэн мэдээг нэгтгэн долоо хоногийн Лхагва гарагт эргэн мэдээлэл бэлтгэж, мэдээ ирүүлсэн лаборатори, Эрүүл мэндийн газар, Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүд, Тандалтын үндэсний нэгж, ЗӨСҮТ, ЭМЯ-нд хүргүүлнэ.
4. Олон улсын шинжтэй Нийгмийн эрүүл мэндийн ноцтой үйл явдал болох халдварт саа, АЦХаХ, MERS CoV, шинэ дэд хэвшинжийн томуу болон нийгмийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулж болзошгүй улаанбурхан, улаанууд, улаанэсэргэнэ, сахуу, хөхүүл ханиад, халдварт менингит, татран, нярайн татран, боом, тарваган тахал, галзуу, холерын үүсгэгч илэрсэн тохиолдолд долоо хоногийн мэдээлэл хүлээлгүйгээр зохих журмын дагуу 2-24 цагийн дотор шуурхай мэдээлнэ.



**Товчилсон үгийн жагсаалт**

ОУЭМД  
ДЭМБ  
ЭМГ  
ХӨСҮТ  
НЛА  
ЭМЯ  
БОЭТ  
ФХУ  
ПГУ  
ДТБХ  
АМЧ  
ДОХ  
RPR  
ТРНА

АЦХАХ  
НIV  
MERS CoV  
НЭМ

Олон улсын эрүүл мэндийн дүрэм  
Дэлхийн эрүүл мэндийн байгууллага  
Эрүүл мэндийн газар  
Халдварт өвчин судлалын үндэсний төв  
Нэгдсэн лабораторийн алба  
Эрүүл мэндийн яам  
Бүсийн оношлогоо эмчилгээний төв  
Фермент холбоот урвал  
Полимеразийн гинжин урвал  
Дархан туяаралт бичил харуур  
Антибиотик мэдрэг чанар  
Дархлалын олдмол хомсдол  
Rapid plasma reagin/ Тэмбүү илрүүлэх тест  
Treponema pallidum haemagglutination/ Тэмбүү  
үүсгэгчийн эсрэг, эсрэг бие илрүүлэх  
шинжилгээ  
Амьсгалын цочмог халтай хам шинж (SARS)  
Хүний дархлал хомсдлын вирус  
Шинэ коронавирүсийн халдвар  
Нийгмийн Эрүүл Мэнд

